

МОНГОЛ УЛС, ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТЫН ЗЭЭЛИЙН БАНК ХООРОНДЫН “ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ, ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСЛИЙН III ҮЕ ШАТ”-НЫ ЗЭЭЛИЙН БОЛОН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ТӨСВИЙН БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН ХУРАЛДААНААР ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ САНАЛ, ДҮГНЭЛТ

2026 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийг үндэслэн Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлснийг нэгтгэн хэлэлцсэн болно.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн хариуцан ажилладаг 32 дэд станцын тоног төхөөрөмж нь ашиглалтын хугацаа хэтэрсэн, технологийн хувьд хоцрогдсон бөгөөд сүүлийн таван жил дэд станцуудын ачаалал 70-100 хувьд хүрч, хүчин чадлын дээд хязгаарт тулсан байдалтай байна. Дээрх төслийн хүрээнд шинээр дэд станц болон хос цахилгаан дамжуулах кабель шугам барьж, зарим дэд станцыг өргөтгөх ажлуудыг гүйцэтгэнэ. Ингэснээр 5 дүүргийн 14 хорооны хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж, иргэн болон аж ахуйн нэгжийн хүлээгдэж буй хүсэлт хангагдаж, нэмэлтээр шинэ хэрэглэгч холбогдох техникийн боломж бүрдэнэ. Мөн Нийслэл Улаанбаатар хотын төлөвлөлт, бүтээн байгуулалттай холбоотой томоохон төслүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах өндөр ач холбогдолтой байна.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар дээрх төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан гэрээтэй холбоотой аливаа маргааныг гуравдагч улсын арбитрын шүүхээр эцэслэн шийдвэрлүүлэхээр гэрээний төсөлд тусгах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат төр, хувийн хэвшлийн түншлэлийг ашиглан эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой эсэх, мөн эрчим хүчний үнийн өсөлт болон үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд зээлээр хэрэгжиж байгаа төслийн төсөвт өртөг өндөр байгаа, мөн гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл төсвийг зээлдүүлдэгч талд буцаах талаар санал хэлсэн болно.


Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн

бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат"-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгов.


**ТӨСВИЙН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР



**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН

